

**Сайн ноён Намнансүрэн нь 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний
нөлөө бүхий удирдагчдын
нэг болох нь**

Н.Хавх - МУИС-ийн Философийн тэнхмийн профессор

Түлхүүр үг: Гарамгай хүн, тусгаар тогтнол, түүхэн баримт, хөдөлгөөний удирдагч.

Энэхүү өгүүлэлд дараах хоёр асуудалд хариу өгөхийг оролдов. Сайн ноён Намнансүрэн нь 1911 оны үндэсний эрх чөлөөний нөлөө бүхий удирдагчдын нэг байв уу, гол удирдагч нь байв уу? Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үед Сайн ноён Намнансүрэн нь тохиолдлын замаар гарч ирсэн хувь хүн байв уу, аль эсвэл түүхийн хөгжлийн шаардлагаар шалгаран тодорч гарч ирсэн гарамгай бие хүн байв уу?

Манж - Хятадын ноёрхолыг түлхэн унагаах зорилготой өрнөсөн 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг удирдаж зохион байгуулсан гол хүн бол VIII Богд Жавзандамба хутагт байв. Харин нь уг хөдөлгөөнийг өрнүүлэх саналыг Хутагтад өргөн барихаас авахуулаад хөдөлгөөнийг удирдан зохион байгуулахад Хутагтай ойр дотно байж түүнд туслаж байсан хүний нэг бол Сайн ноён Намнансүрэн байв гэдгийг гэрчлэх дараах түүхэн баримт байдаг аж. Түүхийн баримтыг О.Батсайханы "Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба. УБ.,2008" номноос авав. Энэ нь цаанаа "Архив внешней политики Российской Империи.Ф.Китайский стол" гэсэн орос улсын түүхийн архивт байгаа баримт юм байна.

Нэг дэхь баримт. "Монголын ноёд тухайлбал Сайн ноёнгоос Жавзандамба хутагтад албан бичгээр хандаж Манжийн засгийн газраас хэрэгжүүлж буй сүүлийн үеийн явдалууд Монголд аюул дагуулж байгааг тэмдэглээд үүний эсрэг ямар арга хэмжээ авбал зохилтойг хэлэлцэх зорилгоор Халхын дөрвөн хан, засаг ноёдыг цуглуулахыг санал болгон тавьсан байна. Хүрээн дэхь Оросын консул Лавдовский 1911 оны 6-р сарын 18-нд бичсэнээр ноёдын цуглаан хийх саналыг анх тэргүүн Сайн ноён хан Намнансүрэн гаргасан байна. (2.26).

Манай түүхчдийн дотор өөр үзэл бодолтой эрдэмтэд ч бас байдаг юм байна. "Халхын түшээт хан, Сэцэн хан аймаг, их шавийн эрх баригчид нэн ялангуяа Г.Цэрэнчимэд манжийн шинэ засгийн бодлого хэрэгжихэд саад хийх явуулгад халхын шарын шашны тэргүүн Жавзандамба хутагтыг татан оруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Тэд 1909 оны 11-р сарын 16-нд засагт хан, Сайн ноён хоёр илгээсэн бичигтээ: сая Богд гэгээнээс буулгасан лүндэнг сосвоос журганаас манай монгол хан, ван, бэнх, бэйл, гүн засаг тайжаас тусгай тооны хэлэлцэх түшмэл сонгон гарган алба хаалган гадаад мужийн сурталыг нээн нэвтрүүлэхэд бэлтгүүлнэ гэх зэргийн бичиг ирсэн гэнэ". (1.9-10). Эндээс да лам Цэрэнчимэд тэргүүтэй ноёдууд анх тэргүүнээ VIII Богдод үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг өрнүүлэх цаг нь болсон гэсэн санааг өргөн барьсан юм болов уу гэсэн дүгнэлт хийсэн юм шиг. Энэ дүгнэлт ч бас л архивийн материалд тулгуурлан хийгдсэн хэрэг. Нэг үзэгдэл, үйлийн талаар архивийн хоёр өөр материалд тулгуурлан нэг л утга агуулагтай дүгнэлт хийгдэх учиртай болов уу. Энэ бол түүхийн ухааны эрдэмтэн мэргэдүүд саруул ухаанаар шүүн тунгаах ажил байхаа.

Хоёр дахь баримт: "Богд уулын арын модон дотор гэр барин нууц зөвөлгөөн хийжээ. хойт айл их Орос улсад найртай сайны ёсоор учрыг гарган туслах харгалзахыг гуйн тусгай төлөөний түшмэл элчин явуулсугай. Явах элчинд Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, жич түшмэл Хайсан нарыг томилон гаргасугай хэмээсэн шийдвэр гаргажээ. Ийнхүү Монголын төлөөлөгчдийг Орос руу явуулах

шийдвэр гаргах хийгээд Монголд эргэлт гаргахад Богд гэгээнтэнтэй хамгийн ойр байж, хамтарсан хоёр ноён бол Сайн ноён, түшээ гүн хоёр бөгөөд Шанзодбын туслах, бага да лам Цэрэнчимэд нар онцгой үүрэг гүйцэтгэсэн тухай хүрээний Оросын консул В.Люба 1912 оны 1-р сарын 22-нд бичсэн тайландаа тэмдэглэжээ"(2.27).

Ер нь аль ч үед улсаа төлөөлж гадаад сууж байгаа ЭСЯ-ны ажилтнууд сууж байгаа улсынхаа талаар судалгаа хийж төр засагт хүргүүлэх үүрэгтэй, тэрхүү судалгаанд тулгуурлаж төр засаг нь бодлого боловсруулдаг байна. Тийм болохоор Оросын консул Лавдовский, Люба нарын бичсэн бүхэн нь үндэслэл сайтай байх учиртай болов уу.

Гурав дахь баримт: "Ханддорж, Цэрэнчимэд, Хайсан гүн нарын Монголын төлөөлөгчид хүрээнээс мөрджээ. Харин манай төлөөлөгчидэд Оросын консул хил нэвтрэх зөвшөөрөл олгосон байдаг. Монголын төлөөлөгчид Богд Жавзандамба хутагт, түшээт хан Дашням, Засагт хан Сономравдан, Сэцэн хан Навааннэрэн, Сайн ноён Намнансүрэн нарын нэр хамтарсан Орос улсаас тусламж эрсэн бичгийг авч явсан билээ. (2.27). Дээрх гурван баримтаас Намнансүрэн бол Манж-Хятадын эрхшээлээс Монголыг чөлөөлөх санаачлагыг анхлан санаачлаж VIII Богдод толилуулсан төдийгүй Орос улсаас тусалцаа авахаар явсан Ханддорж, Цэрэнчимэд, Хайсан нарын Богд хаан тэргүүтэй Сайн ноён оролцсон Халхын бусад ноёдууд гарын үсэг зурсан бичиг авч явсан л улс бололтой. Дараа дараагийн тухайлбал 1912 оны 10-р сарын 21-нд байгуулагдсан гэрээнд Намнансүрэн нь ерөнхий сайдын хувьд засгийн газрын төлөөлөн тэргүүлэн оролцож байв.

Нийгмийн гүн ухаанд түүхийг ард олон бүтээнэ, гэхдээ тэдний эрмэлзэл тэмүүллийг бусдаас илүү ухааран ойлгосон, бусдаас илүү нэр хүндтэй, өнгөрснийг одоотой, одоог ирээдүйтэй холбон ойлгох бусдаас илүү сэтгэн бодох чадвартай, үндэсний эрх ашгыг хувийнхаас ямагт дээгүүр тавьдаг гарамгай хүмүүс тодрон гарч ард олныг удирдан жолоодож түүх бүтээгдэнэ хэмээх сургаал бий. Сайн ноён Намнансүрэн нь 1911 оны үндэсний эрх чөлөөний үед чухамдаа дээрх гоц байдал, шинжээрээ бусад ноёдоос тодрон гарч ирсэн, түүх түүнийг дэвшүүлэн тавьсан гарамгай хүн байв. 1911 онд Оросын консул Лавдовский "Сайн ноён нь бусад ноёдоосоо илүү өөрийн ухааны чанар, ёс суртахуунаараа ялгардаг бөгөөд үүгээрээ ард олны болон хутагтын хүндлэлийг хүлээсэн хүн" гэжээ. (2.26).

Юань улсын үед бичигдсэн "Монгол улсын арван буянт цагаан түүх оршивой" хэмээх номонд хаан хүн долоон бинтэй (эрдэмтэй) байх ёстой. Үүнд: (3.583-589)

1. Өнгөрснийг хөөж онох гүн ухааны бин. (Өнгөрсөн түүхийн хөгжлийн түгээмэл зүй тогтолыг таних ухаан гэх мэт).
2. Ирээдүйг угтаж онох оточын бин. (Өнгөрсөнөөсөө хөөж, одоо ирээдүйг таних ухаан гэх мэт).
3. Битүүг таниж олох үлэм мэргэний бин. (Аливаагийн гүний учир шалтгаан мөн чанарыг таних ухаан гэх мэт).
4. Одоо ахуйг төгс онох магад мэдэхүйн бин. (Нийгмийн хөгжлийн хэт ирээдүйг таних,прогнозчлох ухаан)
5. Бусад самба өгүүлэхүйн урьдаас онохуйн гайхамшигт сэцны бин. (Ард олны

санаа

бодол, хүсэл эрмэлзлийг урьдаас мэдрэх мэдрэмж, угтан, таних ухаан гэх мэт)

6. Аян авын үйлийн ёсоор мэдэх чадал баатарын бин.(Ухаалаг эр зориг, сэтгэлийн тэнхээ, шийдэмгий чанар гэх мэт)

7. Таван ухааныг төгсхийн гэгээн билгийн ухаан хэмээжээ (3.583-589).(Буддын гүн ухааны их таван ухаан : дотоод ухаан, тэжээх ухаан, шалгадаг ухаан, урлах ухаан, дуун ухаан) эдгээр болно.

Сайн ноён Намнансүрэн нь хаан хүнд байх энд өгүүлсэн 7 эрдэм, шинж чанарыг эзэмшсэн түвшиний хувьд бусад ноёдоосоо хол давсан хүн байхаар төсөөлөгдөнө. Тийм чиг болохоороо 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг явуулах саналыг Богд хаанд өргөн барьж, Богд хаантай ойр дотно байж, уг хөдөлгөөнийг удирдаж, амжилтанд хүргэж чадсан ноёнтон, ерөнхий сайд болно.

Ашигласан ном, бүтээл

1. Ж.Болдбаатар. Да лам. УБ., 1997
2. О.Батсайхан. Монголын сүүлчийн эзэн хаан VIII богд Жавзандамба УБ., 2008
3. Н.Хавх. Социологи. Монголын нийгмийн гүн ухааны зарим чиглэл. УБ.,2005. IV боть